

# Та бүхэн мэдэх үү?

## Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

Айчи мужийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бол

# 986

Нэг цагийн үнэлгээ  
иен

2022 оны 10 сарын 1-ний өдрөөс

Өмнөх оноос **31** иенээр **нэмэгдэнэ**

Энэ нь үндсэн болон цагийн ажилтан, оюутан гэх мэт ажил эрхэлж буй бүх хүмүүст, мөн ажил олгогчид хамаарах журам болно!



モンゴル語版

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь ажил эрхэлж буй бүх хүмүүст хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээг баталж буй тогтолцоо болно.

Цахим хуудаснаас харна уу!

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх цахим хуудас (зөвхөн Япон хэл дээр):  
<https://www.saiteichingin.info/>



Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар лавлах бол Айчи мужийн Хөдөлмөрийн товчоо болон ойролцоох Хөдөлмөрийн стандартын хяналтын газарт хандана уу.

Айчи мужийн хөдөлмөрийн товчооны цахим хуудас:  
<https://jsite.mhlw.go.jp/aichi-roudoukyoku/>

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч та бүхэнд

業務改善  
助成金

Хамгийн ихдээ  
6 сая иений  
мөнгөн дэмжлэг  
үзүүлнэ



Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

# "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тогтолцоо" гэдэг нь,

Хөдөлмөр эрхэлж буй бүх хүмүүсийн хөдөлмөрийн хөлсний (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ) доод үнэлгээг тогтоох тогтолцоо болно!

Нас, цагийн ажилтан, оюутан зэргээс үл хамааран бүх хөдөлмөр эрхлэгчдэд эрх тэгш үйлчилнэ.



## Хэрхэн харах вэ?

Шалгахыг хүсэж байгаа хөдөлмөрийн хөлс-нийхөө нэг цагийн үнэлгээг гаргаад, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (нэг цагийн үнэлгээ) -тэй харьцуулж үзье!

### Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харьцуулах арга

Таны хөдөлмөр эрхэлж буй аймаг хот дүүргийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бичнэ үү. (\*2)

<b>1</b>	Нэг цагийн үнэлгээний тохиолдолд	Нэг цагийн хөлс ¥	≥	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн хөлс) ¥				
<b>2</b>	Нэг өдрийн үнэлгээний тохиолдолд	Нэг өдрийн хөлс ¥	÷	Нэг өдрийн ажлын дундаж цаг цаг	=	Нэг цагийн хөлс ¥	≥	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн хөлс) ¥
<b>3</b>	Нэг сарын үнэлгээний тохиолдолд	Сарын хөлс ¥	÷	Нэг сарын ажлын дундаж цаг цаг	=	Нэг цагийн хөлс ¥	≥	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ(цагийн хөлс) ¥
<b>4</b>	Дээрх 1, 2, 3 нэгтгэсэн байх тохиолдолд	Тухайлбал, үндсэн цалин нь өдрөөр тооцож, бусад нэмэгдэл (хөдөлмөрийн нэмэгдэл) нь сараар тооцдог тохиолдолд		① Үндсэн цалин (Өдрийн хөлс) → 2-р тооцооллоор нэг цагийн үнэлгээг бодож гаргана. ② Нэмэгдэл хөлс (сарын цалин) → 3-р тооцооллоор нэг цагийн үнэлгээг бодож гаргана. ③ ① болон ②-р нэмсэн дүн ≥ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн үнэлгээ)				

(\*1) Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулж үзэхдээ дараах нэмэгдлүүдийг оролцуулж тооцохгүй.

① Үйл явдлын олговор (Гэр бүлтэй болсны олговор г.м) ② Нэг сарын хугацаа өнгөрөх тутамд олгох олговор (урамшуулал г.м) ③ Тогтсон ажлын цаг хэтэрсэн тохиолдолд тооцогдох нэмэгдэл хөлс (илүү цагийн нэмэгдэл г.м) ④ Тогтсон ажлын өдрөөс гадна ажилласан өдрийн нэмэгдэл хөлс (амралтын өдрийн нэмэгдэл хөлс г.м) ⑤ Оройны 22 цагаас өглөө 5 цаг хүртэлх ажлын цагт төлөгдөх хөдөлмөрийн хөлсөнд, өдрийн ажлын цагийн хөлсний үнэлгээний зөрүү дүнг (шөнийн цагийн нэмэгдэл г.м) тооцно ⑥ Нэмэгдэл олговор, унааны нэмэгдэл болон гэр бүлийн нэмэгдэл олговор гэх мэт

(\*2) Дэлгэрэнгүй тооцоолол хийх арга болон ажлын гүйцэтгэл, борлуулалтын хувиас олгох хөлсийг тооцоолол хийх арга зэргийг Хөдөлмөрийн товчоо болон Хөдөлмөрийн стандарт хяналтын газраас лавлана уу.

Ажил олгогч болон хөдөлмөр эрхлэгч ч гэсэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг заавал нягтлах хэрэгтэй.



Ухаалаг утас болон гар утсаа ашиглан өөрийн амьдарч буй орон нутгийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодруулж харна уу! (зөвхөн Япон хэл дээр)

## 業務改善助成金

Хамгийн ихдээ 6 сая иений мөнгөн дэмжлэг үзүүлнэ.

"Бизнесийн үйл ажиллагааг сайжруулахад үзүүлэх дэмжлэг" гэдэг нь үйлдвэрлэлийн бүтээмжээ сайжруулж, "ажлын байран дахь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (ажлын байрны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ)-г нэмэгдүүлсэн жижиг, дунд аж ахуйн нэгжид үзүүлэх дэмжлэгийг хэлнэ. Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд олголтын нөхцөлөөс хамааран тухайн зардлын зарим хэсгийг дэмжлэг болгож олгодог.



### Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч та бүхэнд

Хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэхийг дэмжих дэмжлэгийн хөрөнгийг идэвхитэй ашиглацгаая.

Бизнесийн үйл ажиллагааг сайжруулахад үзүүлдэг дэмжлэгийн тогтолцооны танилцуулга видео байгаа.

Илүү дэлгэрэнгүйг эндээс харна уу. (зөвхөн Япон хэл дээр)

業務改善助成金

検索



### Олголтын нөхцөл

**1**  
Ажлын байрны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн

**2**  
Нэмэгдүүлсэн дүнгээр ажилчдад цалин олгосон

**3**  
Үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулахад тустай тоног төхөөрөмж зэргийг нэвтрүүлсэн

**4**  
Ажилтан халсан, цалинг бууруулсан зэрэг олголтод үл нийцэх хүчин зүйл байхгүй.

Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад зарцуулсан зардлын зарим хэсгийг дэмжлэг болгож олгох.

### Дэмжлэгийг олгох хүртэлх дараалал

**1**  
Дэмжлэг олгох өргөдөл, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг хамгийн ойр хот, мужийн Хөдөлмөрийн газарт хүргүүлэх.



**2**  
Олгохоор шийдвэрлэсний дараа хүргүүлсэн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах.

**3**  
Хөдөлмөрийн газарт үйл ажиллагааны үр дүнг тайлагнах.



**4**  
Дэмжлэгийг олгох

### Мэргэжилтнээс үнэ төлбөргүй зөвлөгөө авах

Хөдөлмөрийн хөлс нэмэгдүүлэлттэй холбоотой ямар нэг асуудал байвал Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтыг дэмжих Төвд ирж зөвлөгөө авна уу.

Илүү дэлгэрэнгүйг эндээс харна уу. (зөвхөн Япон хэл дээр)

働き方改革推進支援センター

検索

### Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтыг дэмжих сан

Японы засгийн газрын Санхүүгийн Корпораци нь ажлын байран дахь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч ажилладаг хүмүүст зориулж, тоног төхөөрөмжийн болон эргэлтийн хөрөнгийн зээл олгодог.

Илүү дэлгэрэнгүйг эндээс харна уу. (зөвхөн Япон хэл дээр)

働き方改革推進支援資金

検索

リサイクル適性  
この印刷物は、印刷用の紙へリサイクルできます。